

**Банк бус санхүүгийн байгууллагуудын 2007 оны
1 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн
нэгтгэлийн танилцуулга**


2007 оны 03-р сарын 31-ний байдлаар Хороонд 140 Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) бүртгэлтэй байснаас 113 ББСБ буюу 80.7 хувь нь 2007 оны 1-р улирлын санхүүгийн тайлангаа ирүүлснийг нэгтгэлд хамруулж, үлдэх 27 ББСБ-уудын санхүүгийн тайлангийн мэдээллийг өмнөх онд ирүүлж байсан мэдээллээр нэгтгэлд хамрууллаа. 1 дүгээр улирлын тайлангаа ирүүлсэн 113 ББСБ-уудын 13 нь буюу 12.0 хувь нь санхүүгийн тайлангаа электорон хэлбэрээр ирүүлсэн байна. 2007 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлангаа ирүүлээгүй шалтгаан:

- дүрмийн сан бүрдээгүй 5 (Кредит лизинг, Альфа кредит, Монголын валютын төв бирж, Чин ази, Молор орд),
- татан буугдах гэж байгаа 4 (Хаан хөмрөг, Афин, Мистермо кредит, Ундрах)
- тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй 2 (Империал гоулд, Ялгуулагч),
- холбоо барих боломжгүй 4 (Дархан сайхан булаг, Хан буурал кредит, Цэцэрлэг-ар, Хануй сан)
- хариуцсан байцаагч нь тодорхойгүй 5 (Материал лизинг, Монголт хан инвест, Тэргүүн хөгжлийн хөтөч, Цагаан Ажнай, Эрдэм хөгжил)
- тайланг буруу маягтаар ирүүлсэн 2 (Санкредит групп, Мөнх арилжаа)
- улсын мөрдөн байцаах газарт байгаа 1 (Инвест кредит),
- хяналт шалгалтын газарт шалгагдаж байгаа 1 (Гурван бар кредит),
- удирдлага нь солигдсон 1 (Мөрөн кредит),
- шалтгаангүйгээр тайлан ирүүлээгүй 1 (Монгол лизинг)

I. АКТИВ

Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 70.1 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19.7 тэрбум төгрөг буюу 39.1 хувиар, өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 0.9 тэрбум төгрөг буюу 1.3 хувиар өссөн байна (Зураг-1).


Зураг-1



2007 оны 1 дүгээр улиралд эргэлтийн хөрөнгө 59.0 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 84.1 хувь, эргэлтийн бус хөрөнгө 11.1 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 15.9 хувийг эзэлж байгаа бол өнгөрсөн оны мөн үед эргэлтийн хөрөнгө 47.2 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 93.7 хувь, эргэлтийн бус хөрөнгө 3.2 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 6.3 хувийг эзэлж, нийт хөрөнгөнд эзлэх эргэлтийн хөрөнгийн хувь

хэмжээ 10.4 пунктээр буурч, эргэлтийн бус хөрөнгө энэ хэмжээгээр өссөн байна (Зураг-2).


Зураг-2




Нийт хөрөнгөнд эзлэх эргэлтийн хөрөнгийн хэмжээ буурахад нөлөөлсөн шалтгаан нь 2007 оны 1 дүгээр улиралд эргэлтийн хөрөнгө 24.9 хувиар өсч байхад эргэлтийн бус хөрөнгө 3.5 дахин түүн дотроо үндсэн хөрөнгө 3.7 дахин өссөнтэй холбоотой байна.

Эргэлтийн хөрөнгөнд эзлэх цэвэр зээлийн хувь хэмжээ 2007 оны 1 дүгээр улиралд 50.5 хувь болж өнгөрөгч 2006 оны мөн үеийнхээс 5.0 пунктээр өссөн байна (Зураг-3).

Зураг-3




Зээлийн бүтцийг харахад төгрөгийн нийт зээлийн 91.9 хувь нь хэвийн, 4.0 хувь нь хугацаа хэтэрсэн, 4.2 хувь нь чанаргүй зээл, валютын нийт зээлийн 90.7 хувь нь хэвийн, 3.4 хувь нь хугацаа хэтэрсэн, 5.9 хувь нь чанаргүй зээл байна (Зураг-4).



II. ПАССИВ

2007 оны 1 дүгээр улиралд өр төлбөр 24.0 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 34.2 хувьд хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 12.4 тэрбум төгрөгөөр буюу 2.1 дахин нэмэгдсэн байна (Зураг-5).

Зураг-5



Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар нийт өр төлбөрийн 52.9 хувийг банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, 27.5 хувийг бусад эх үүсвэр, 11.6 хувийг төслийн зээлийн санхүүжилт, 7.2 хувийг бусад пассив эзэлж байна. Нийт өр төлбөрт хамгийн өндөр жин эзэлдэг банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл өмнөх оны мөн үеийнхээс хувийн жингийн хувьд 22.4 пунктээр, тоо хэмжээнийхээ хувьд 3.6 дахин өссөн нь өр төлбөрийн ихээхэн өсөлтөд нөлөөлсөн байна (Хүснэгт-1).

Нийт өр төлбөрийн хэмжээ, бүтэц, өсөлт/бууралт

Үзүүлэлтүүд	2006-I		2007-I		Өсөлт/бууралт	
	Тоо (мян.төг)	Эзлэх хувь	Тоо (мян.төг)	Эзлэх хувь	Тоо (мян.төг)	Хувь
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	3 550 778.9	30.5	12 691 102.3	52.9	9 140 323.4	3.6 дахин
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хугацаа хэтрэлт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад эх үүсвэр	3 082 465.9	26.4	6 603 815.5	27.5	3 521 349.6	2.1 дахин
Итгэлцлийн үйлчилгээний тооцооны өглөг	1 168 933.3	37.9	3 380 480.2	51.2	2 211 546.9	2.9 дахин
Факторингийн тооцооны өглөг	0.0	0.0	167 960.8	2.5	167 960.8	0.0
Мөнгөн гуйвуулга, төлбөр тооцооны өглөг	1 913 532.6	62.1	3 055 374.5	46.3	1 141 841.9	159.7
Санхүүгийн деривативын өглөг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	36 975.1	0.3	41 074.5	0.2	4 099.4	111.1
Төслийн зээлийн санхүүжилт	2 270 056.4	19.5	2 787 902.6	11.6	517 846.2	122.8
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	119 899.6	1.0	130 788.9	0.5	10 889.3	109.1
Бусад пассив	2 597 186.3	22.3	1 727 096.2	7.2	- 870 090.1	66.5
Нийт өр төлбөр	11 657 362.2	100.0	23 981 780.0	100.0	12 324 417.8	2.1 дахин

1 дүгээр улиралд өөрийн хөрөнгийн 89.5 хувийг ердийн хувьцаа, 3.6 хувийг хуримтлагдсан ашиг, 2.6 хувийг хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/, 2.0 хувийг нөөцийн сан, 1.6 хувийг тухайн үеийн ашиг, 0.5 хувийг хувь нийлүүлэгчдийн өмчийн бусад хэсэг, 0.2 хувийг давуу эрхтэй хувьцаа, 0.1 хувийг нийгмийн хөгжлийн сан бүрдүүлж байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүтцэд онцын өөрчлөлт гараагүй байна (Хүснэгт-2).

Өөрийн хөрөнгийн нийт хэмжээ, бүтэц, өсөлт/бууралт

Үзүүлэлтүүд	2006-I		2007-I		Өсөлт/бууралт	
	Тоо (мян.төг)	Эзлэх хувь	Тоо (мян.төг)	Эзлэх хувь	Тоо (мян.төг)	Хувь
Ердийн хувьцаа	33 699 258.8	87.0	41 285 762.2	89.5	7 586 503.4	122.5
Давуу эрхтэй хувьцаа	487 991.8	1.3	114 680.1	0.2	- 373 311.7	23.5
Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	1 382 035.6	3.6	1 185 535.3	2.6	- 196 500.3	85.8
Дахин үнэлгээний нэмэгдэл	73 877.8	0.2	280.0	0.0	- 73 597.8	0.4
Нөөцийн сан	915 692.6	2.4	924 148.2	2.0	8 455.6	100.9
Нийгмийн хөгжлийн сан	47 945.0	0.1	42 880.8	0.1	- 5 064.2	89.4
Хувь нийлүүлэгчдийн	605 737.6	1.6	224 630.0	0.5	- 381	37.1


өмчийн бусад хэсэг					107.6	
Тухайн үеийн ашиг/алдагдал	265 800.9	0.7	723 787.3	1.6	457 986.4	272.3
Хуримтлагдсан ашиг/алдагдал	1 241 423.2	3.2	1 649 648.6	3.6	408 225.4	132.9
Өөрийн хөрөнгийн дүн	38 719 763.3	100.0	46 151 352.5	100.0	7 431 589.2	119.2

III. ОРЛОГО, ЗАРЛАГА

2007 оны 1 дүгээр улиралд ББСБ-уудын нийт цэвэр ашиг 721.4 сая төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс 455.6 сая төгрөгөөр буюу 2.7 дахин өссөн байна (Зураг-6).

Зураг-6

Өүяүд аө өа пәү.р а



Тайлант хугацаанд Зөн сан монгол 35806.8 мян.төгрөг, Монгол лизинг 27196.9 мян.төгрөг, Өрнөх инвест сан 14484.2 мян.төгрөг, Футур эволюшн 12228.6 мян.төгрөг, Би энд Жи финанс 12168.7 мян.төгрөг, Санкредит групп 11364.9 мян.төгрөг, Грассланд 5646.5 мян.төгрөг, Очиртэтим 4276.9 мян.төгрөг, Номин карт 4012.0 мян.төгрөг, Ти энд Ди финанс 2782.1 мян.төгрөг, Дэлгэр экспресс 2139.4 мян.төгрөг, Чингис хаан холдинг 1947.4 мян.төгрөг, Ийс уэст факторинг 1540.6 мян.төгрөг, Цэнтүүл 1508.2 мян.төгрөг, Таванбат кредит 670.6 мян.төгрөг, Би И Ай 508.5 мян.төгрөг, Гурван бар кредит 501.8 мян.төгрөг, Нью Ази 305.8 мян.төгрөг, Од орчлон 228.2 мян.төгрөг, Тодсанаа 206.9 мян.төгрөг, Дорнын хөтөч 240.5 мян.төгрөг, Хунай сан 90.0 мян.төгрөг, Гэрэл инвест 72.6 мян.төгрөг, Топфинанс 9.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2007 оны 1 дүгээр улиралд нийт орлого 3.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9 тэрбум төгрөг буюу 35.6 хувиар өссөн бол нийт зардал 2.5 тэрбум төгрөгт хүрч 0.4 тэрбум төгрөг буюу 17.6 хувиар өссөнөөр ердийн үйл ажиллагааны цэвэр ашиг 2.5 дахин өссөн байна.

ББСБ-уудын нийт орлогын 94.6 хувь нь санхүүгийн орлого, 5.4 хувь нь үйл ажиллагааны бусад орлого байж өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад онцын өөрчлөлт гараагүй байна. Нийт зардлын 40.2 хувийг санхүүгийн зардал, 50.1 хувийг үйл ажиллагааны бусад зардал, 9.7 хувийг эрсдлийн зардал бүрдүүлж өмнөх оны мөн үетэй харьцуулахад эрсдлийн зардлын нийт зардалд эзлэх хувь 5.1 пунктээр буурч, харин үйл ажиллагааны бусад зардлын нийт зардалд эзлэх хувь 5.2 пунктээр өссөн байна (Хүснэгт-3).

Хүснэгт-3

Үзүүлэлтүүд	2006-I	2007-I	Өсөлт/бууралт
-------------	--------	--------	---------------

	Тоо (мян.төг)	Эзлэх хувь	Тоо (мян.төг)	Эзлэх хувь	Тоо (мян.төг)	Хувь
Санхүүгийн орлого	2 327 583.2	95.6	3 122 724.4	94.6	795 141.2	134.2
Үйл ажиллагааны бусад орлого	107 624.5	4.4	179 464.7	5.4	71 840.2	166.8
Нийт орлого	2 435 207.7	100.0	3 302 189.1	100.0	866 981.4	135.6
Санхүүгийн зардал	853 446.7	40.3	1 001 649.2	40.2	148 202.5	117.4
Болзошгүй эрсдлийн зардлууд	313 217.2	14.8	241 839.9	9.7	- 71 377.3	77.2
Үйл ажиллагааны бусад зардал	949 861.0	44.9	1 246 216.9	50.1	296 355.9	131.2
Боловсон хүчний холбогдолтой зардал	331 405.4	15.7	462 714.2	18.6	131 308.8	139.6
Үйл ажиллагааны бусад зардал	618 455.6	29.2	783 502.8	31.5	165 047.2	126.7
Нийт зардал	2 116 524.9	100.0	2 489 706.0	100.0	373 181.1	117.6
Ердийн үйл ажиллагааны цэвэр ашиг/алдагдал/	318 682.8		812 483.1		493 800.3	2.5 дахин

Цаашид анхаарах асуудалууд:

1. Байцаагчид хариуцсан ББСБ-уудынхаа тайланг тогтоосон цаг хугацаанд нь шаардаж авах, ирсэн тайланг сайн шалгах тал дээр дутагдалтай ажиллаж байгаагаас санхүүгийн тайлангийн нэгтгэл цаг хугацааны хувь хоцрох, мэдээллийн үнэн бодит байдал алдагдах явдал байна.
2. Нийт ББСБ-уудын 82.0 хувь нь тайлангаа e-mail-ээр ирүүлэх боломжтой учраас цаашид online-аар авч байх тал дээр илүү анхаарах шаардлагатай.